



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 523

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1,2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн "Монгол Кувейтын байгаль хамгаалах төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус үйлдвэрийн газар нь 73,141,174.72 (далан гурван сая нэг зуун дөчин нэгэн мянга нэг зуун далан дөрвөн төгрөг далан хоёр мөнгө) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. "Монгол Кувейтын байгаль хамгаалах төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. "Монгол Кувейтын байгаль хамгаалах төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Х.Ерхуланд дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2.1. Үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг эдийн засгийн үндэслэлтэй төлөвлөх;

2.2. Үйлдвэрийн газраас үзүүлж буй үйлчилгээний тарифыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн, батлан мөрдөж ажиллах;

2.3. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй барилга байгууламжийг засварлах, эх үүсвэрийг төсөл арга хэмжээ болон эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах;

2.4. Үйлдвэрийн газрын санхүүгийн ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн анхан шатны баримтыг үнэн зөв бүрдлийг ханган бүртгэх, тайлан мэдээг үнэн бодитой илэрхийлэх;

2.5. Үйлдвэрийн газрын онцлогт таарсан санхүүгийн програм хангамжийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.6. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, мөнгөн кассын үйл ажиллагааны журам боловсруулж мөрдөн ажиллах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх;

2.7. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад журмын дагуу авлага, өглөгийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулж байх;

2.8. Үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй эргэлтийн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлэн ажиллах.

2.9. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх;

2.10. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг ханган ажиллах;

2.11. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах.

3. Төрийн өмчийн эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтэд болон төрийн өмчийн ашиглалт хамгаалалт, хадгалалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т, үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах болон үр ашигтай ажиллахад тусламж дэмжлэг үзүүлж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

4. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн
10 дугаар тогтоолын хавсралт



“МОНГОЛ КУВЕЙТЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ,
ДУТАГДАЛ ТҮҮНИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс гадуур бэлтгэсэн үндсэн хөрөнгө	1,960,000.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй хүнсний материалын худалдан авалт	67,623,174.72	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.5 дахь хэсэг, 48 дүгээр зүйл, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах
3	Үргүй зардал	3,558,000.00	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын дүн		73,141,174.72 (далан гурван сая нэг зуун дөчин нэгэн мянга нэг зуун далан дөрвөн төгрөг далан хоёр мөнгө)	